



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАР**

# **САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

*Худалдан авах ажиллагааны 2013 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
аудит*

Аудитын код: YAG-CAГ/2014/04/СТА-ТШЗ

2014 оны 2 дугаар сар

Улаанбаатар хот



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗРЫН ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.02.25 № 3/179  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Худалдан авах ажиллагааны газрын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Худалдан авах ажиллагааны газрын удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх зохистой бөгөөд хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА

УАА0122

С.ЭНХЗАЯА

0700-2



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараахь хаягаар харилцана уу:

YAG-ын Санхүүгийн аудитын газрын  
дарга С.Энхзаяа  
Утас: 261663  
Цахим хаяг: enkhzayas@mnao.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл  
Утас: 260512  
Цахим хаяг: oyungerels@mnao.mn

Аудитор: Ж.Ядмаа  
Утас: 2631740  
j\_yadmaa@yahoo.com

Монгол Улсын  
Үндэсний аудитын газар

Засгийн газрын IY байр  
Улаанбаатар-46  
Бага тойруу 6

АГУУЛГА

ХУУДАС

Оршил .....	2
Санхүүгийн дотоод хяналт.....	2
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд	2
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	3
Аудитын санал дүгнэлтийн үндэслэл .....	3

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2014 оны 2 дугаар сар

## **Оршил**

Худалдан авах ажиллагааны газрын төсвийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитыг дуусгавар болгосон тухай энэхүү тайланг удирдлагад танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн дотоод хяналтын сул тал, үүсэх эрсдэл, хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

### **Санхүүгийн дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Худалдан авах ажиллагааны газрын даргын дотоод хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаархи өөрийн мэдээллийн сантай харьцуулан түүврийн сорил гүйцэтгэж, шинжилгээ хийлээ. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

### **Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

- Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны касс, харилцахын баримтыг түүврийн аргаар шалган үзэхэд 10.5 сая төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр хийсэн байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 3.1.4, 4.1.2, 7.7 дугаар заалтуудыг зөрчсөн байна.
- Худалдан авах ажиллагааны газарт орон тооны мөнгөн кассын нярав байхгүй, одоогийн байдлаар аж ахуйн нярав давхар гүйцэтгэж байна. Мөнгөн кассын 2013 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 02 хүртэлх хугацааны тайланд байгууллагын дарга, нягтлан бодогч, нярав нарын гарын үсэггүй, төрийн сангаар хянуулаагүй, , 2013 оны 07, 08,12 дугаар саруудын тайланг төрийн сангаар хянуулаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.1, 2.2, 2.5, 3.1, 3.2, 3.5, 3.6, 3.9 заалтуудыг зөрчсөн байна.
- Санхүүгийн байдлын тайланд бусдаас авах 1.2 сая төгрөгийн авлагатай гэж бүртгэсэн нь Сангийн сайдын "Дансны жагсаалт батлах тухай" 2005 оны 276 дугаар тушаалын авлага дансанд "Зээлээр үзүүлсэн ажил, үйлчилгээ, нийлүүлсэн бүтээгдэхүүний төлбөрийг нэхэмжлэн авах мөнгөн дүнг энэ дансанд бүртгэнэ " гэж заасантай нийцэхгүй байна.
- Тус газрын дарга нь 2 төрлийн утас барьдаг бөгөөд утасны төлбөрт 1581.9 мянган төгрөг төлснөөс шалтгаалан тайлант хугацаанд шуудан холбооны зардлыг 160.6 мянган төгрөг буюу 2.6 хувиар хэтрүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор баталсан лимитээс 801.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зөрчил илэрлээ.
- Төсвийн мөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал:ХААГазар нь төрийн захиргааны алба учраас дүрэмт хувцас хэрэглэх эрх зүй байхгүй байтал Шилмэл загвар ХХК-д дүрэмт хувцасны үнэнд 743.0 мянган төгрөгийг гэрээ хэлцэлгүйгээр шилжүүлсэн байна. Энэ нь "Төсвийн тухай" хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

## **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Худалдан авах ажиллагааны газрын 2012 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж, 2 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 50.0 хувийг хэрэгжүүлж, биелэлтийг гарган ирүүлсэн байна.

## **Аудитын санал дүгнэлтийн үндэслэл**

Худалдан авах ажиллагааны газрын төсвийн 2013 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Санхүүгийн аудитын газрын даргад санал болгож байна.

**ҮАГ-САГ/2014/04/-СТА-ТШЗ**

2014 оны 2 дугаар сар

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	18 500,0	18 500,0
Кассанд байгаа бэлэн мөнгө	18 500,0	18 500,0
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	-	-
<b>АВЛАГА</b>	<b>1 159 337,9</b>	<b>1 159 337,9</b>
Бусад авлага	1 159 337,9	1 159 337,9
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3 269 540,0</b>	<b>20 049 360,3</b>
Хангамжийн материал	2 912 540,0	19 692 360,3
Бусад	357 000,0	357 000,0
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4 447 377,9</b>	<b>21 227 198,2</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7 511 605,8</b>	<b>516 219 643,1</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>7 511 605,8</b>	<b>489 630 908,4</b>
Авто тээврийн хэрэгсэл	-	144 799 999,4
Хуримтлагдсан элэгдэл	-	(9 653 333,3)
Машин, тоног төхөөрөмж	15 693 514,0	231 749 082,8
Хуримтлагдсан элэгдэл	(13 456 008,7)	(55 627 338,4)
Тавилга, аж ахуйн эд хогшил	13 648 768,7	201 630 518,9
Хуримтлагдсан элэгдэл	(8 374 668,2)	(23 268 021,0)
<b>Биет бус хөрөнгө</b>	-	<b>26 588 734,8</b>
Програм хангамж	-	32 514 501,6
Хасагдуулга	-	(5 925 766,9)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7 511 605,8</b>	<b>516 219 643,1</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11 958 983,7</b>	<b>537 446 841,3</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>1 159 338,5</b>	<b>12 261 351,0</b>
<b>Өглөг</b>	<b>1 159 338,5</b>	<b>12 261 351,0</b>
Ажиллагчидтай холбогдсон өглөг	729 338,5	566 338,0
Бусад өглөг	430 000,0	11 695 013,0
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>1 159 338,5</b>	<b>12 261 351,0</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>1 159 338,5</b>	<b>12 261 351,0</b>
Засгийн газрын оруулсан капитал	7 511 605,8	7 511 605,8
Өмнөх үеийн үр дүн	3 288 039,4	3 288 039,4
Тайлант үеийн үр дүн	-	514 385 845,1
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10 799 645,3</b>	<b>525 185 490,3</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11 958 983,7</b>	<b>537 446 841,3</b>

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	-	-
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	-
Улсын төсвөөс	-	1 294 644 193,7
Урсгал	113 368 024,9	1 294 644 193,7
Тусламжийн орлого	-	76 153 490,0
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	187 461 486,4
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	185 146 219,6
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	2 315 266,8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	-	<b>1 558 259 170,1</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	-	-
<b>АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	-	<b>567 472 553,4</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	507 525 954,0
Цалин	48 992 237,8	491 128 647,0
Бусад нэмэгдлүүд	-	16 397 307,0
Унаа, болон бусад нөхөн олговор	-	16 397 307,0
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>5 389 150,2</b>	<b>59 946 599,4</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	-	59 946 599,4
Бүтцийн өөрчлөлтийн цалингийн НДШ	-	59 946 599,4
<b>Бараа үйлчилгээний урсгал зардал</b>	-	<b>264 011 955,6</b>
Бусад бараа үйлчилгээний зардал	55 698 561,5	264 011 955,6
Бичиг хэргийн материал	1 514 432,0	21 961 057,7
Тээвэр, шатахууны зардал	1 995 650,0	23 227 477,0
Шуудан холбооны зардал	1 876 787,5	5 399 612,3
Дотоод томилолтын зардал	-	510 925,0
Гадаад томилолтын зардал	-	17 545 680,0
Ном, хэвлэлийн зардал	201 400,0	925 300,0
Сургалт семинарын зардал	296 836,0	6 984 700,0
Жижиг эд хогшил худалдан авах зардал	-	1 227 350,0
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэ түргэн элэгдэл зү	-	1 227 350,0
Төлбөр хураамж, жижиг татварууд	924 374,0	5 744 920,0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	-	14 400 000,0
ТӨГАҮ Харуул хамгаалалтын хөлс	-	14 400 000,0
Урсгал засварын зардал	41 189 999,0	93 439 851,0
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	-	1 300,0
Элэгдлийн зардал	-	72 643 782,7
Бусад бараа үйлчилгээний зардал	7 699 083,0	-
<b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>	-	<b>207 443 425,0</b>
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	-	207 443 425,0
Бүтцийн өөрчлөлтийн урсгал зардал	-	182 771 016,0
Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)	-	24 672 409,0
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	-	<b>4 945 500,0</b>
<b>Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж</b>	-	<b>4 945 500,0</b>
Мөнгөн хэлбэрээр	-	2 145 000,0
Нэг удаагийн тэтгэмж	-	2 145 000,0
Шагнал, тэтгэмж	-	2 800 500,0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>110 079 949,5</b>	<b>1 043 873 434,0</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>3 288 075,5</b>	<b>514 385 736,1</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	-	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	-	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>3 288 075,5</b>	<b>514 385 736,1</b>

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Тусламж, санхүүжилтын орлого</b>	-	<b>1 294 644 193,7</b>
<b>Улсын төсвөөс</b>	-	<b>1 294 644 193,7</b>
Урсгал	113 205 025,0	1 294 644 193,7
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	-	<b>166 866 315,4</b>
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	166 866 315,4
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	164 551 048,6
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	2 315 266,8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	-	<b>1 461 510 509,1</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>54 218 422,6</b>	<b>567 610 053,9</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>45 173 113,5</b>	<b>507 500 454,0</b>
Цалин	45 173 113,5	468 321 687,0
Бусад нэмэгдлүүд	-	39 178 767,0
Унаа, болон бусад нөхөн олговор	3 741 540,0	39 178 767,0
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>5 303 769,1</b>	<b>60 109 599,9</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	5 303 769,1	60 109 599,9
Тэтгэврийн даатгалын шимтгэл	5 303 769,1	60 109 599,9
<b>Бараа үйлчилгээний урсгал зардал</b>	-	<b>321 396 938,3</b>
Бусад бараа үйлчилгээний зардал	-	321 396 938,3
Бичиг хэргийн зардал	2 499 902,0	15 279 331,0
Тээвэр, шатахууны зардал	1 995 650,0	11 527 246,0
Шуудан, холбооны зардал	1 930 787,5	6 260 612,3
Дотоод томилолтын зардал	-	510 925,0
Гадаад томилолтын зардал	-	17 545 680,0
Ном, хэвлэлийн зардал	498 236,0	983 200,0
Сургалт семинарын зардал	-	8 339 700,0
Жижиг эд хогшил худалдан авах зардал	2 001 759,0	8 841 410,0
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\	-	3 179 280,0
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэ түргэн элэгдэл з	2 001 759,0	5 662 130,0
Төлбөр хураамж, жижиг татварууд	1 600 264,0	6 533 090,0
Төлбөр хураамж бусад зардал	1 600 264,0	6 533 090,0
Харуул, хамгаалалтын зардал	-	11 520 000,0
Урсгал засварын зардал	41 249 999,0	234 055 744,0
<b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>	<b>6 691 505,0</b>	<b>101 372 409,0</b>
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	6 691 505,0	101 372 409,0
Бүтцийн өөрчлөлтийн урсгал зардал	-	76 700 000,0
Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)	6 691 505,0	24 672 409,0
Шагнал тэтгэмж	-	2 875 500,0
Нэг удаагийн буцалтгүй тусламж	500 000,0	2 070 000,0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>113 186 525,0</b>	<b>995 324 901,1</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)</b>	<b>18 500,0</b>	<b>466 185 608,0</b>
<b>Хөрөнгийн орлого</b>	-	-
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	-	<b>4 945 500,0</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	94 128 085,0
Хөрөнгийн бусад зардал	-	372 057 523,0
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	<b>466 185 608,0</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)</b>	-	<b>(466 185 608,0)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>18 500,0</b>	<b>0,0</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0,0	18 500,0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18 500,0	18 500,0



## АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС				
2					
3	2012 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	0	0	0	0
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0	0
7	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0	0
8	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	0	0
10		0	0	0	0
11	2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7 511 605,8	-	3 288 039,4	10 799 645,3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7 511 605,8	-	3 288 039,4	10 799 645,3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
17	Тайлант үеийн үр дүн	-	-	514 385 845,1	514 385 845,1
18	2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7 511 605,8	-	517 673 884,5	525 185 490,3

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙАН

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1 533 194 703,0</b>	<b>1 384 810 512,1</b>	<b>148 384 190,9</b>	<b>90,3</b>
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1 533 194 700,0	1 384 810 509,1	148 384 190,9	90,3
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1 133 194 700,0	1 012 752 986,1	120 441 713,9	89,4
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>1 127 277 600,0</b>	<b>1 007 807 486,1</b>	<b>119 470 113,9</b>	<b>89,4</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606 175 600,0	507 500 454,0	98 675 146,0	83,7
Үндсэн цалин	559 772 000,0	468 321 687,0	91 450 313,0	83,7
Унаа, болон бусад нөхөн олговор	46 403 600,0	39 178 767,0	7 224 833,0	84,4
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67 809 600,0</b>	<b>60 109 599,9</b>	<b>7 700 000,1</b>	<b>88,6</b>
Тэтгэврийн даатгал	43 151 500,0	60 109 599,9	(16 958 099,9)	139,3
Тэтгэмжийн даатгал	4 931 200,0	-	4 931 200,0	-
ҮОМШӨ ний даатгал	6 164 500,0	-	6 164 500,0	-
Ажилгүйдлийн даатгал	1 233 400,0	-	1 233 400,0	-
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	12 329 000,0	-	12 329 000,0	-
<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>453 292 400,0</b>	<b>440 197 432,3</b>	<b>13 094 967,7</b>	<b>97,1</b>
Бичиг хэрэг	10 750 000,0	15 279 331,0	(4 529 331,0)	142,1
Тээвэр (шатахуун)	16 960 000,0	11 527 246,0	5 432 754,0	68,0
Шуудан холбоо	6 100 000,0	6 260 612,3	(160 612,3)	102,6
Дотоод албан томилолт	5 000 000,0	510 925,0	4 489 075,0	10,2
Гадаад томилолт арга хэмжээ	20 000 000,0	17 545 680,0	2 454 320,0	87,7
Ном хэвлэл авах	985 600,0	983 200,0	2 400,0	99,8
Эд хогшил худалдан авах	104 000 000,0	102 969 495,0	1 030 505,0	99,0
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\	95 000 000,0	92 817 365,0	2 182 635,0	97,7
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэ түргэн элэг\	4 000 000,0	5 662 130,0	(1 662 130,0)	141,6
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\	5 000 000,0	4 490 000,0	510 000,0	89,8
Урсгал засвар	234 266 600,0	234 055 744,0	210 856,0	99,9
Сургалт, семинар зохион байгуулах зардал	5 000 000,0	8 339 700,0	(3 339 700,0)	166,8
Төлбөр хураамж болон бусад зардал	10 000 000,0	6 533 090,0	3 466 910,0	65,3
Төлбөр хураамж бусад зардал	10 000 000,0	6 533 090,0	3 466 910,0	65,3
Харуул хамгаалалтын зардал	14 400 000,0	11 520 000,0	2 880 000,0	80,0
Мэдээлэл сурталчилгааны зардал	25 830 200,0	24 672 409,0	1 157 791,0	95,5
Татаас ба урсгал шилжүүлэг	5 917 100,0	4 945 500,0	971 600,0	83,6
Өрх гэрт олгох шилжүүлэг	5 917 100,0	4 945 500,0	971 600,0	83,6
Шагнал тэтгэмж	4 333 400,0	2 875 500,0	1 457 900,0	66,4
Нэг удаагийн буцалтгүй тусламж	1 583 700,0	2 070 000,0	(486 300,0)	130,7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>400 000 000,0</b>	<b>372 057 523,0</b>	<b>27 942 477,0</b>	<b>93,0</b>
1. Дотоод хөрөнгө оруулалт	400 000 000,0	372 057 523,0	27 942 477,0	93,0
Төсвийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалтын д	400 000 000,0	372 057 523,0	27 942 477,0	93,0
төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж	400 000 000,0	372 057 523,0	27 942 477,0	93,0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>100 000 000,0</b>	<b>1 461 510 509,1</b>	<b>(1 361 510 509,1)</b>	<b>1 461,5</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100 000 000,0	164 551 048,6	(64 551 048,6)	164,6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2 315 266,8	(2 315 266,8)	-
Төсвөөс санхүүжих	-	1 294 644 193,7	(1 294 644 193,7)	-
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>18 500,0</b>	<b>(18 500,0)</b>	<b>-</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>18 500,0</b>	<b>(18 500,0)</b>	<b>-</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
АЖИЛЛАГСАД БҮГД	65,0	62,0	-	100,0
Удирдах ажилтан	3,0	3,0	-	100,0
Гүйцэтгэх ажилтан	59,0	56,0	-	94,9
Үйлчлэх ажилтан	3,0	3,0	-	100,0
СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/	-	-	-	-
Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад	-	-	-	-